# Бүгд Найрамдах Монгол Ард Улсын
# Сайд нарын Зөвлөлийн
# ТОГТООЛ

1977 оны 8 дугаар сарын 6-ны өдөр

Дугаар 245

Улаанбаатар хот

**Автомашин, механизмын бааз байгуулах тухай**

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлөөс ТОГТООХ нь:

Улаанбаатар хотод байгаа материал-техникийн хангамжийн ерөнхий газар, конторын автомашин, ,механизмыг нэгтгэн төвлөрүүлж хорооныхоо харьяанд автомашин, механизмын бааз байгуулан аж ахуйн тооцооны үндсэн дээр ажиллуулахыг Улсын материал-техникийн хангамжийн хороо /н.РИНЧИНПИЛЖЭЭ/-д зөвшөөрсүгэй. Уг авто баазад төв, орон нутгийн материал-техникийн хангамжийн газар, байгууллагын автомашин, механизмын техникийн үзлэг үйлчилгээ, сэлбэг хэрэгслийн хангамжийн асуудлыг хариуцуулсугай.

БНМАУ -ын Сайд нарын Зөвлөлийн орлогч дарга — С.ЛУВСАНГОМБО

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн Хэрэг эрхлэх газрын нэгдүгээр орлогч дарга — З.СААРАЛ

Хуулбар үнэн: Тогтоол ангийн эрхлэгчийг /Ш.МЯГМАР/

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн ТОГТООЛ АНГИ